

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 01 дүгээр сарын 24

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

“Аймгийн хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт, зөвлөмжийг 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

Дундговь аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээний хүрсэн түвшнийг хүрэх түвшинд харьцуулан хувиар тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр тооцсон болно.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг нийт 5 бүлгийн хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулсан. Үүнийг бүлгээр нь харуулбал:

Нэг. Хүний хөгжлийн бодлогын хүрээнд 17 арга хэмжээ

Хоёр. Эдийн засгийн бодлогын хүрээнд 11 арга хэмжээ

Гурав. Засаглалын бодлогын хүрээнд 3 арга хэмжээ

Дөрөв. Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 3 арга хэмжээ

Тав. Орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд 6 арга хэмжээг тус тус төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Дундговь аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг нэгтгэн, Засгийн газрын 2020 оны 12 сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “**БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ**”-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээ болон зорилтыг

үнэлж үзэхэд 5 зорилтын 40 арга хэмжээний биелэлт 90,12 хувьтай байгаа нь эхний хагас жилийн биелэлтээс 7,6 хувиар өссөн байна.

Үүнээс үр дүнтэй буюу 100 хувьтай-33, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувь-1, 48 хувь-1, 66.6 хувь-1 65.9 хувь-1, 30 хувь-1 23.7-1, үр дүнгүй буюу 0 хувь-1 хэрэгжилтийн дундаж 90,12 хувьтай байна.


Хяналт-шинжилгээ үнэлгээний дүнгээс харахад удаашралтай хэрэгжиж байгаа болон үр дүнгүй хэрэгжсэн 3 арга хэмжээ нь тус ажлын гүйцэтгэгч “Суурь” компани, туслан гүйцэтгэгч компани хоёрын маргаан, санаачилгагүй байдлаас шалтгаалан үр дүнгүй хэрэгжсэн байна.

Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 16 дугаар хуралдаанд танилцуулан хурлаас “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээг өгч хурлын 52 дугаар тогтоолоор баталгаажуулсан.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Бүлэг 1. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1. Зорилго 1.1. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд нэгдсэн эмнэлгийн барилгыг ашиглалтад оруулах.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй аймгийн Нэгдсэн эмнэлгийн 100 ортой барилгыг 2023 оны 10 дугаар сард ашиглалтад оруулж үйл ажиллагаа жигдэрсэн. Ингэснээр эрүүл мэндийг үйлчилгээг хүргэх тохилог орчин нөхцөл бүрдүүлсэн.

- 1.1.2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж нийлүүлэх

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Компьютер томографыг улсын төсвийн 1 тэрбум 500 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар авч суурилуулан нэн шаардлагатай 35 хүнд шинжилгээ оношилгоо хийж, тархины хагалгааг 2 хүнд хийснээр 3 дахь шатлалын эмнэлэгт үзүүлж буй урсгалыг буурууллаа. Мөн Эрүүл мэндийг дэмжих төвд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 272,8 сая төгрөгийн ходоодны уян дурангаар хангаж нийт 5003 иргэнд дурангийн үзлэг хийж эмчилгээ зөвлөгөө өглөө. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад 12 нэр төрлийн 2,4 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдаж нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 93,5 хувьд хүрсэн.



1.2.5. “Бага олимп” наадмыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах

“Бага олимп – 2023” наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2023 оны А/603 дугаар захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, удирдамжийг боловсруулан батлуулж, бүх сумдын Засаг дарга нарт аймгийн Засаг даргын 2023 оны 01/1312 тоот албан бичгээр хүргүүлж, бэлтгэл ажлыг хангуулсан. Энэхүү наадмыг зохион байгуулахад 3 удаа удирдлага, арга зүйгээр ханган ажилласан. Үүний үр дүнд нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн тоо 30538 хүрсэн байна.



1.3.1. Сайнцагаан, Дэлгэрцогт сумын цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулсан.

Сайнцагаан сумын 150 ортой 2 дугаар цэцэрлэгийн барилгыг 2,710.0 сая төгрөгийн гэрээ байгуулан 100 хувь гүйцэтгэсэн. Мөн Дэлгэрцогт сумын 150 ортой цэцэрлэгийн барилгыг 2,447,3 сая төгрөгийн гэрээ байгуулан 100 хувь гүйцэтгэсэн бөгөөд Улсын комисс ажиллан ашиглалтад хүлээн авч, үйл ажиллагаа тогтмолжин явуулж байна.



1.3.5. Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх



“Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд 2023 онд аймгийн ИТХ-аас 750,0 сая төгрөгийг батлуулан төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан төрийн албан хаагчийг мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, зөвлөгөөн, орон нутагт дутагдалтай боловсон хүчин бэлтгэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр зохион байгуулан ажиллалаа. Үүний үр дүнд Боловсон хүчний хангалт 64.9% - 78 % хүрсэн. 151 албан хаагчийн ажиллах орчин нөхцөл сайжирсан. Аймгийн хэмжээнд 9 төрийн албан хаагчийн амьдах орчин нөхцөл сайжирч орон байраар хангагдсан.



1.3.6. Засгийн газар болон аймгийн захиалгаар дотоод, гадаадад суралцагчидтай гэрээ хийж, орон нутагт нэн шаардлагатай боловсон хүчинг бэлтгэсэн.



2023-2024 оны хичээлийн жилд орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр 3,4-р дамжаанд суралцаж байгаа 37 оюутан сурагчидтай гэрээ байгуулан 42.2 сая төгрөгийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамруулан бэлтгээд байна.

1.4. Зорилго 1.4. Хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх

1.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгыг ашиглалтад оруулсан.



Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв 2023 онд нээлтээ хийснээс хойш 927 иргэнд хөдөлмөр, хөдөлгөөн, хэл заслын үйлчилгээ, портеж хөтөлбөрийн хөгжлийн дэмжлэг үйлчилгээ, сэтгэл засал болон мэргэжлийн нийгмийн ажилтны үйлчилгээ үзүүлсэн байна.

Мөн 521 иргэнд байгууллагын танилцуулга, зөвлөгөө, сургалт, мэдээлэл хүргэлээ.Сэргээн засах тусламж үйлчилгээнд хамрагдсан Насанд хүрэгчдэд болон хүүхдэд дараах үр дүн гарч байна. Үүнд:

1. Эмчийн өгсөн командыг биелүүлдэг болж байна.
2. Анхаарал төвлөрөх хугацаа уртасч байна.
3. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилж үйлчлүүлэх иргэдийн тоо нэмэгдсэн.
4. Тухайн орон нутагтаа тусламж үйлчилгээ авснаар Улаанбаатар хотруу явах зардал, мөнгөө хэмнэж байна.
5. 3 иргэнийг Эрт оношилж 3 дугаар шатлалын эмнэлэг рүү шилжүүлсэн.
6. Нийгмийн харилцаанд идэвхтэй хамрагдаж олон нийттэй чөлөөтэй харилцах чадвар нэмэгдсэн.
7. Нумтай улавч, хөлийн чиг аймагтаа анх удаа хийсэн.

Бүлэг 2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.2.1. Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах Хулд суманд 01 дүгээр сарын 27-ны өдөр “ТЭМЭЭНИЙ ӨВ СОЁЛ” өвлийн эвент арга хэмжээг зохион байгуулж, Өмнөговь аймгийн 7 сум, Дундговь аймгийн 3 сумын тэмээчид оролцож, гадаад, дотоодын 518 жуулчид үзэж, сонирхсон.



Цагаан суварга дахь “Говь каравансерай” жуулчны баазтай хамтран “Сэтгэшгүй оддын чуулган” арга хэмжээг зохион байгуулж 165 аялагч, жуулчид үзэж сонирхсон.



Дуу хуур, өв, соёлын өлгий нутгийн бренд болсон Уяхан замбуу тивийн наран урлагийн их наадмыг "Их газрын чулуу" байгалийн цогцолбор газарт зохион байгуулж 15 сумын 3200 морин хуурч, уртын дуучид оролцож, зохион байгуулах багийн 1000 хүн, гадаад, дотоодын 41000 хүн үзэж сонирхсон.



Адаацаг сумын Сүм хөх бүрд байгалийн үзэсгэлэнт газарт "Адуучны өв соёлын баяр" эвент арга хэмжээг зохион байгуулж 4 аймгийн 72 адуучин залуус оролцож, 900 гаруй зочид төлөөлөгчид үзэж сонирхсон. Нийт 4 арга хэмжээнд 42583 гадаад, дотоодын жуулчид үзэж сонирхсон. Улсын төсвийн 10.0 сая төгрөг, орон нутгийн төсвийн 30.0 сая төгрөг зарцуулсан.



Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулах, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэн үр дүнтэй томоохон ажлууд хийгдсэн. Үүнд

№	Арга хэмжээ	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Хандив	Нийт
1	Соёлын сэргэлт	10.000.000	20.000.000	600.000	30.600.000
2	Уяхан замбуу тивийн наран	160.000.000	661.500.000		821.500.000
3	Нүүдэлчин	22.800.000	24.900.000		47.700.000
4	Адуучны өв соёл		10.000.000		10.000.000
5	Дундговь түншлэл		3.000.000		3.000.000
6	Соёлын бүтээлч сар	7.000.000			7.000.000
7	Соёлын эрхийн бичиг	6.020.000			6.020.000
	Нийт	205.820.000	719.400.000	600.000	925.820.000

Аймгийн хэмжээнд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд нийт 925.820.000 төгрөгийг заруулсан байна.Энэ онд нийт 1958 бүтээлийн үзэсгэлэн худалдаанд 53881 хүн хамрагдсан.Орон нутгаас “Соёлын бүтээлч үйлдвэрлэл”-ийг дэмжиж ажилласны үр дүнд иргэд, хүүхэд багачуудыг соён гэгээрүүлэх, өвлүүлэх, сурталчлах, орон нутгийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлсэн.”Уяхан замбуу тивийн наран” урлагийн арга хэмжээг орон нутагт зохион байгуулснаар“Соёлын аялал жуулчлал”-ын тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Бүлэг 3.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.2.1. Түр Хамгаалах байрыг бий болгож, үйл ажиллагааг тогтворжуулах



Аймгийн 2023 оны төсөвт хүүхэд хамгаалал болон хүчирхийллийн чиглэлээр 250,0 сая төгрөгийн төсөвтэй“Түр хамгаалах байр”-ны хөрөнгийг шийдвэрлүүлэн ажлын гүйцэтгэгчээр “Зууны гүүр” ХХК-нийг сонгон шалгаруулан, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд улсын комисс хүлээн авч үйл ажиллагаа тогтмол явуулж байна.Давхардсан тоогоор 20760 хүүхдэд 125,584,907 төгрөгийг урьдчилан сэргийлэх болон хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг тус тус үзүүлсэн. Хамтарсан багаар 2023 онд нийт 59 кейс бүртгэгдэж, кейсийг 100% шийдвэрлэж ажилласан.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хийсэн ажлын сонсгол мэдээллийг хэлэлцэн хүүхэд, гэр бүл рүү чиглэсэн ажлуудыг эрчимжүүлэх, бодит үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оныг хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын жил болгон зарлахаар аймгийн иргэдийн төлөөлөгчдийн 16-р хуралдаанаар шийдвэрлэв.


Бүлэг 4.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4.1. Зорилго 4.1. Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлнэ.

Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Дундговин ногооруулъя” хөтөлбөрийн хэрэгжилт 94 хувьтай хэрэгжсэн бөгөөд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр 141 аж ахуйн нэгж, байгууллагын 1284 иргэн 124944 мод, сөөгийг тарьж арчилгаа, усалгаа хийж, нийт модны тоо 285529-д хүрч, тарьсан модны талбайн хэмжээ өмнөх жилээс 4,2 хувиар өсөв.Нийт 124944 мод, сөөгийг тарьснаас 82.3 хувьтай ургуулсан байна.



МОДНЫ ТОО



5. Бүлэг 5. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1.1. Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны багцад тус аймгийн Луус сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлын 1,0 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд тухайн оны төсвийн гүйцэтгэл 100 хувьтай, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 52.3 хувьтай байна.



1.3. “Түмний хорооллын хэсэгчилсэн рөнхий төлөвлөгөөний ажлын зураг төсөв боловсруулах” зөвлөх үйлчилгээг Бес онцгой дизайн ХХК 50.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэж байна. Хаус хороололын ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг Сонголт дизайн ХХК-тай 49,5 сая төгрөгөөр байгуулсан.

5.1.6. Сайнцагаан сумын Нийтийн халуун усны засвар хийх



Нийтийн халуун усны засварын ажил "Элбата" ХХК 249.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Ажлын явц 100 хувьтай. 2023 оны 12 сарын 28 өдөр комисс хүлээн авч ашиглалтад оруулсан. Ингэснээр иргэд стандартын шаардлага хангасан, эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах орчин нөхцөл бүрдсэн.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Дундговь аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг нэгтгэн, Засгийн газрын 2020 оны 12 сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан **“БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ”**-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээ болон зорилтыг үнэлж үзэхэд 5 зорилтын 40 арга хэмжээний биелэлт 90,12 хувьтай байгаа нь эхний хагас жилийн биелэлтээс 6,4 хувиар өссөн байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад нийт 40 арга хэмжээнээс 2 арга хэмжээ удааширсан, 1 арга хэмжээ үр дүнгүй хэрэгжсэн байна. Энэ нь Тухайн барилгыг барьж буй гүйцэтгэгч компаний хариуцлагагүй байдал болон зохион байгуулалтаас шалтгаалан удааширсан буюу үр дүнгүй хэрэгжсэн үзэж байна.


Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хандив тусламж, төсөл хөтөлбөрийн хүрээнд нийт 47512.9 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд 45735.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган сум, агентлагийн удирдлагууд, төрийн албан хаагчдад бодлогын баримт бичиг боловсруулах, тайлагнах арга зүйн 6 удаагийн сургалтыг 422 албан хаагчдад зохион байгуулж, үр дүнг жилийн эцсийн ажил дүгнэх үзүүлэлтэд оруулан тооцлоо.



Үүний үр дүнд төрийн албан хаагчдын бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналтад ахиц гарч байгаа нь хяналт-шинжилгээ үнэлгээний явцад харагдаж байна.

Мөн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг иргэдийн саналд үндэслэн төлөвлөлтийн шаардлага, зарчимд нийцүүлэн боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.



2023 оны эхний хагас байдлаар жилийн хөгжлийн төлөвлөгөөний удаашралтай хэрэгжиж байгаа 5 арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тодруулан аймгийн Засаг даргад танилцуулан "СОНСГОЛ" мэдээллийн арга хэмжээг зохион байгууллаа. Энэ үеэр зохион байгуулалтаас шалтгаалсан арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх, санхүүжилт төсөв хөрөнгөтэй холбоотой арга хэмжээг 2024 оны орон нутгийн төсөвт суулгах, дараа оны байгууллагын төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэн ажиллахыг холбогдох хэлтэс, агентлагийн дарга нарт үүрэг чиглэлийг өгснөөр хэрэгжилтийн хувь эхний хагас жилээс 6,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2023 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 90,12 хувийн хэрэгжилттэй буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлж үнэлгээний тайланг хүргүүлж байна.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг ойлгомжтой, тоо баримттайгаар үр дүнд хүрсэн эсэхийг тодорхой нотлох баримттайгаар тайлагнаж хэвших.

Төлөвлөлтийг боловсруулахдаа санхүүжилт нь шийдэгдсэн, орон нутгийн хөгжил нөлөөлөхүйц, иргэдийн амьдралд эерэг нөлөөтэй үр дүнг тооцож болохуйц зорилт, арга хэмжээг томъёолоход анхаарч ажиллах.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС